



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 14 өдөр

Дугаар 5/04

Ховд

Я.Өмирханыг томилох тухай


Монгол Улсын Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн 60.2, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3, Улсын Их Хурлын 2007 оны 73 дугаар “Улс төрийн албан хаагчийн албан ажлын онцгой нөхцлийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэх тогтоох тухай” тогтоолын 1 дэх заалтууд, Ховд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн хуралдааны 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг нь Авлигатай тэмцэх газрын 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 05/14549 тоот албан бичгээр хянагдаж ирсэн Ягмусын Өмирханыг 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн Ховд сумын Засаг даргаар томилсугай.

2. Я.Өмирханыг Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын “Улс төрийн албан тушаал эрхэлдэг зарим албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох тухай” 11 дүгээр хавсралтын дагуу 1015984 төгрөг /Нэг сая арван таван мянга есөн зуун наян дөрвөн/-өөр цалинжуулж, албан ажлын онцгой нөхцлийн нэмэгдлийг албан тушаалын сарын цалингийн 30 хувиар тооцон сар бүр олгохыг Ховд сумын Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч /Т.Ернур/-д зөвшөөрсүгэй.

3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдол бүрт тайлбар, мэдүүлэг гаргаж ажиллахыг Я.Өмирханд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax B/04 Ch
02 0047